



ᠪᠤᠯᠭᠠᠨ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ,
ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠳᠤᠯᠠᠨ ᠲᠤᠬᠠᠢ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠤᠭᠤᠯᠭᠠ

БУЛГАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2013-02 сар

ГАРЧИГ

- I. АЙМГИЙН ТӨСӨВ
- II. АЖ ҮЙЛДВЭР
- III. ХОЛБООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- IV. ЭРҮҮЛ МЭНД
- V. НИЙГМИЙН ХАЛАМЖ
- VI. НИЙГМИЙН ДААТГАЛ
- VII. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ
- VIII. ХӨДӨӨ АЖ АХУЙ
- IX. ГЭМТ ХЭРЭГ
- X. ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Танилцуулгыг хянасан:

Хэлтсийн дарга:
Б.Цолмонбаяр

Танилцуулгыг бэлтгэсэн:

Ахлах мэргэжилтэн:
Ц.Ганцэцэг

Мэргэжилтэн:
А.Нарантуяа
Ц.Батчимэг
Б.Баярцэнгэл
Д.Халиун

I. Аймгийн төсвийн орлого


2013 оны 02 сарын байдлаар улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 4049.7 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 30.3 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 3122.8 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 131.4 хувиар нэмэгдсэн байна.

Мөн нийт төсвийн орлого ба тусламжийн дүн 7172.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 100.1 хувиар нэмэгдсэн байна.

Нийт орлогын 43,6 хувийг урсгал орлого, 56,4 хувийг тусламжийн орлого эзэлж байна.

2013 оны 02 сарын байдлаар улсын төсвийн байгууллагын зарлага ба цэвэр зээлийн дүн 3100,3 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 133,8 хувь болж өссөн бөгөөд үүний 85,5 хувийг бараа үйлчилгээний зардал, 14,5 хувийг татаас ба урсгал шилжүүлэг эзэлж байна.



Орон нутгийн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 1676,6 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 86,6 хувиар өссөн байна. Орон нутгийн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 98,3 хувийг урсгал зардал эзэлж байгаагийн 69,6 хувийг бараа үйлчилгээний зардал, 30,4 хувийг татаас ба урсгал шилжүүлэг эзэлж байна. Орон нутгийн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 1,7 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Нийт төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 4776,9 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн

үеэс 14,4 хувиар буурсан байна. Нийт төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 99,4 хувийг урсгал зардал эзэлж байгаагийн 85,6 хувийг бараа үйлчилгээний зардал, 14,4 хувийг татаас ба урсгал шилжүүлэг эзэлж байна. Нийт төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 0,6 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна

II. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2013 оны эхний 02-р сарын байдлаар 744.8 сая төгрөгт хүрч 2012 оны мөн үеийнхээс 190.8 хувиар буюу 354.4 сая төгрөгөөр өссөн байна. (Хавсралт ...)



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг салбараар нь харуулбал 2012 оны мөн үеийнхээс боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 283.9 хувиар, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлт 204.8 хувиар, уул уурхайн үйлдвэрлэлт 122.7 хувиар тус тус өссөн байна. (Хавсралт ...)

Аж үйлдвэрийн салбар нь 2013 оны 02-р сарын байдлаар 1051.4 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсаны 42.0 хувь буюу 441.7 сая төгрөгийг боловсруулах салбар, 42.1 хувь буюу 441.9 сая төгрөгийг дулааны эрчим хүчний салбар, 15.9 хувь буюу 167.8 сая төгрөг нь уул уурхайн салбарын борлуулалт тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 185.1 хувь болж өссөн байна.

Аж үйлдвэрийн ажиллагсад өмнөх оны мөн үеэс 100.8 хувиар өссөн байна. (Хавсралт ...)

III. Шуудан холбоо

Шуудан холбооны үйлчилгээний орлого 2013 оны 02-р сарын байдлаар 44.06 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 21.6 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс шуудан холбооны үйлчилгээний орлого 1.01 хувиар өссөн байна.

Суурин телефон цэгийн тоо 2013 оны 02-р сарын байдлаар 1097 болж 2012 оны мөн үеийнхээс 18,3 хувиар буурсан байна.

Утасгүй телефоны тоо тайлант үеийн байдлаар 1185, үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 34.8 мянга болсон бол кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо 0.95 мянга болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 13.6 хувиар буурсан байна.

Мөн 2013 оны 02-р сарын байдлаар интернетийн үйлчилгээний цэг 7 байгаа бөгөөд үйлчлүүлэгчдийн тоо 1002 байгаа, үүнээс байнгын хэрэглэгчдын тоо 40 байна.

IV. Эрүүл мэнд

Амьд төрсөн хүүхдийн тоо 2013 оны 02 сарын байдлаар 147, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 хүүхдээр, амаржсан эх 147 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 эхээр тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд 39 хүн нас барсаны 7 хүн эмнэлэгт нас барсан байна.

Мөн 0-5 настай хүүхдийн нас баралт урьд оныхоос 1 хүүхдээр буюу 7,3 хувиар буурсан байна.



Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөд 160 болсон нь өмнөх оны мөнүеэс 9,5 хувиар буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 0,8 хувийг гэдэсний халдварт өвчин, 58,0 хувийг амьсгалын замын халдварт өвчин, 25,0 хувийг бэлэгсийн замаар дамжих халдвар, 9,0 хувийг арьсны халдварт өвчин тус тус эзэлж байна.

V. Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн нийт тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн зардалд 320.5 сая төгрөг зарцуулж 2113 хүнд дээрх тэтгэмж, тусламж олгогдсон байна.

Нийгмийн халамжийн сангаас нь тайлант хугацаанд 2113 хүнд 320.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгосон байна.

“ Эхийн алдарт “ I зэргийн одонтой 1741 эх, II зэргийн одонтой 2780 эх жилд нэг удаа тэтгэмжид хамрагдаж нийтдээ энэ арга хэмжээнд 627.4 сая төгрөг зарцуулагдсан байна.

Өндөр настанд үзүүлдэг мөнгөн тэтгэмжийг тайлант хугацаанд 353 хүнд 32,0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 249 иргэнд 22,2 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдэд 13,1 сая төгрөг, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсөн 22 иргэнд 1,9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2013 оны 02-р сарын байдлаар жирэмсэн, хөхүүл 1662 эхэд 104.5 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

VI.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сан нь 2013 оны 02 сарын байдлаар 3095,1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг 12415 иргэнд олгосноос тэтгэвэрийн даатгалын сангаас 2774,1 сая төгрөгийг, тэтгэмжийн даатгалын сангаас 75,7 сая төгрөгийг олгосон байна. Тэтгэвэр тэтгэмжийг төрлөөр нь авч үзвэл үйлдвэрчний осол мэргэжлээс шалтгаалах өвчинд 35,2 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжинд 34,1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалд **175,8** сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

VII. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн хэлтсийн 02 сарын мэдээгээр ажил идэвхитэй хайж байгаа 159 иргэн байна.

Тайлант сард 11 хүн шинээр ажилд орсон бөгөөд үүний 81,8 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Шинээр ажилд орсон иргэдээс төрийн албанд 11 иргэн ажилд орсон байна.

Тайлангийн хугацаанд ажилгүйчүүдийн бүртгэлээс идэвхигүйн улмаас 76 иргэн хасагдсан байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны ангиллаар нь харуулбал 6,9 хувь буюу 11 нь 16-24 насны залуучууд, 38,3 хувь буюу

61 нь 25-34 насныхан, 30,8 хувь буюу 49 нь 35-44 насныхан, 23,9 хувь буюу 38 нь 45-60 насныхан байна.

VIII. Хөдөө аж ахуй


Том малын зүй бус хорогдол

2013 оны эхний 2 сарын байдлаар 6583 том мал хорогдсоноос тэмээ 4, адуу 318, үхэр 568, хонь 2683, ямаа 3010 зүй бусаар хорогдож, өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.6 дахин өссөн байна. Өмнөх оны мөн үед нийт том малын зүй бус хорогдлын 42.0

хувийг хонь, 38.2 хувийг ямаа, 10.0 хувийг үхэр, 9.8 хувийг адуу, эзэлж байсан бол 2013 оны 02-р сарын байдлаар нийт том малын зүй бус хорогдлын 45.72 хувийг ямаа, 40.76 хувийг хонь, 8.63 хувийг үхэр, 4.83 хувийг адуу, 0.06 хувийг тэмээ эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол


	2012	2013
Тэмээ	0	4
Адуу	249	318
Үхэр	251	568
Хонь	1066	2683
Ямаа	969	3010
Бүгд	2535	6583



Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2013 оны 02-р сарын байдлаар 70 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 23 хэргээр буюу 48,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (Зураг-IV-1) БҮСТЗЭТХэрэг 32 бүртгэгдэн 17 хэргийг илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 53 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18 хувиар буурсан байна.


Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо (жил бүрийн 02-сарын байдлаар)




Булган, Могод, Рашаант, Хишиг-Өндөр, Бугат, Бүрэгхангай, Орхон, зэрэг сумдад өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал гэмт хэргийн гаралт өссөн ба Гурванбулаг, Сэлэнгэ, Хангал, Баян-Агт сумдад гэмт хэрэг урьд оны мөн үеэс буурсан байна. Хулгайн гэмт хэрэг 42 бүртгэгдэж 16 хэргээр буюу (97,9 хувиар), Малын хулгай 18 бүртгэгдэж 8 хэргээр буюу (69,3 хувиар), Иргэдийн хулгай 24 бүртгэгдэж 12 хэргээр буюу (100 хувиар), ХАБАЖЭГХэрэг 4 бүртгэгдэж урьд оны мөн үеийнхээс 2 хэргээр буурсан байна. Бусдыг санаатайгаар алах гэмт хэрэг, санамсаргүй алсан, ашиглалт, албан тушаал, булаах, хүчингийн гэмт хэрэг 0 бүртгэгдсэн байна.

Мөн гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн яллагдагчдын 1,5 хувь нь албан хаагч, 4,5 хувь нь ажилчин, 30,3 хувь нь малчин, 53 хувь нь ажилгүйчүүд байна

Хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын тоо (жил бүрийн эхний 02-р сарын байдлаар)




Гэмт хэрэгт холбогдогсдын нийгмийн байдал (2013 оны 02-р сарын байдлаар)



2013 оны 02-р сарын байдлаар гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 76,6 сая төгрөгийн хохирол учирсан байна. Нийт хохирлын **20,5** сая төгрөг буюу 20,7 хувийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая.төг (02-р сарын байдлаар)




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн дотор танхайн хэрэг 3 бүртгэгдсэн буюу 1 дахин өссөн бол, ИЭЧЭМЭ 15 бүртгэгдсэн буюу 7 хэргээр, дээрмийн хэрэг 1 бүртгэгдсэн буюу 1 дахин, бусад төрлийн гэмт хэрэг 5 бүртгэгдсэн буюу 2 хэргээр өссөн байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 16 бүртгэгдэж 60 хувиар өссөн байна.


Х. Цаг агаарын урьдчилсан мэдээ 2013 оны 03-р сар

Энэ сарын агаарын дундаж температур нь 6-11 градус хүйтэн байх ба нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас 1.0 градусаар хүйтэн, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна.



1 дүгээр зураг. 3 дугаар сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

3-р сарын агаарын температурын хоногийн явц




Нэгдүгээр арав хоногийн сүүлийн хагаст болон хоёрдугаар арав хоногийн эхээр Орхон-Сэлэнгэ, Эг, Түүл голын хөндийгээр шөнөдөө 24-29, өдөртөө 13-18 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 19-24, өдөртөө 9-14 градус хүйтэн байна. Мөн хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр өмнөх үеэсээ 4-6 градусаар хүйтэн байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэс бүх

нутгаар харьцангуй дулаарч шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 16-21 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нутгийн хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, нэг болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар цас, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар хур тунадас, уулаараа нойтон цас орно.



2 дугаар зураг. 3 дугаар сард орох хур тунадасны урьдчилсан мэдээ

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхээр 12-14 м/с хүртэл ширүүсч цасан ба шороон шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

3 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим, нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас хүйтэн байна. Ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим ба Орхон-Сэлэнгийн сав, Эг голын

хөндийгөөр олон жилийн дунджаас бага цас орох төлөвтэй.

Одоогийн байдлаар аймгийн нийт нутгаар битүү цастай байгаа ба Рашаант, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг, Тэшиг, Хангал сумын ихэнх хэсгээр, Хутагийн Хонгор, Тээл багийн хойд хэсэг, Сэлэнгэ сумын IV болон III-р баг, Хишиг-Өндөр сумын хойд хэсгээр цасны зузаан 10-23см (хунгарласан газартаа үүнээс их), нягт нь 0,13-0,28г/см³ хүрч нягтарч хатуурсан зузаан цастайн улмаас мал өвөлжилтийн байдал хүндрээд байна.

Цаашид цастай байгаа нутгаар 3 дугаар сард жиндүү хүйтэн байж, сарын дунд үеэр цасан болон шороон шуурга шуурч, мал төллөх, төл хүлээн авах ажилд таагүй нөлөөлж болзошгүй байгааг онцгой анхаарна уу!

Хавсралт

1. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

өссөн дүн, мян.төгрөг

	ОРОН НУТГИЙН ТӨСӨВ		УЛСЫН ТӨСӨВ		НИЙТ ДҮН	
	2012 II	2013 II	2012 II	2013 II	2012 II	2013 II
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1349173,4	3122840,2	5813967,6	4049752,9	7163141,0	7172593,1
А. УРСГАЛ ОРЛОГО	787946,8	3121338,9	896501,7	6929,0	1684448,5	3128267,9
I. ТАТВАРЫН ОРЛОГО	760665,5	2966761,1	0,0	0,0	760665,5	2966761,1
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27281,3	154577,8	896501,7	6929,0	923783,0	161506,8
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	7029,4	1501,3	0,0	0,0	7029,4	1501,3
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	554197,2	0,0	4917465,9	4042823,9	5471663,1	4042823,9
1. НӨАТ-ын шилжүүлэг	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0
2. Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	554197,2	0,0	0,0	0,0	554197,2	0,0
3. Улсын төсвийн санхүүжилт	0,0	0,0	4797561,1	4042823,9	4797561,1	4042823,9
4. Эрүүл мэндийн даатгал	0,0	0,0	119904,8	0,0	119904,8	0,0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	898137,8	1676638,3	4688483,2	3100324,0	5586621,0	4776962,3
УРСГАЛ ЗАРДАЛ	898137,8	1648452,7	4688483,2	3100324,0	5586621,0	4748776,7
Бараа, үйлчилгээний зардал	879744,0	1147787,5	3413185,7	2915098,2	4292929,7	4062885,7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	488794,2	748520,6	2103596,5	1956300,0	2592390,7	2704820,6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45331,9	78920,9	206291,0	216436,1	251622,9	295357,0
Бараа, үйлчилгээний бусад зардал	345617,9	320346,0	1103298,2	742362,1	1448916,1	1062708,1
Татаас ба урсгал шилжүүлэг	18393,8	500665,2	1275297,5	185225,8	1293691,3	685891,0
Татаас	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0
Өрх гэрт олгох шилжүүлэг	18393,8	500665,2	1275297,5	185225,8	1293691,3	685891,0
Улсын төсөвт өгсөн шилжүүлэг	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0,0	28185,6	0,0	0,0	0,0	28185,6
НИЙТ ТЭНЦЭЛ	451 035,6	1 446 201,9	1 125 484,4	949 428,9	1 576 520,0	2 395 630,8

2. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, жил бүрийн 2-р сарын байдлаар

мян.төг

Аж үйлдвэрийн салбар	2009 II	2010 II	2011 II	2012 II	2013 II	2013. II % 2012. II
Аж үйлдвэр-Бүгд	330948.7	244283.3	419478.9	390455.6	744857.0	190.8
Уул уурхайн олборлох салбар	158340.7	.0	34357.4	185265.0	227287.1	122.7
Нүүрс олборлолт	158340.7	.0	34357.4	185265.0	227287.1	122.7
Боловсруулах аж үйлдвэр	87521.1	49559.5	245226.3	123054.0	349328.1	283.9
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэлт	30770.5	.0	143755.5	67176.1	260550.0	387.9
Мах, загас, жимс ногоо үйлдвэрлэлт	.0	.0	555.5	1025.4	800.0	78.0
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	.0	.0	.0	.0	.0	0.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	29352.4	40811.7	54540.3	25620.6	53840.0	210.1
Согтууруулах ундаа үйлдвэрлэлт	16716.4	.0	.0	.0	.0	0.0
Оёдол, нэхмэлийн үйлдвэрлэлт	2786.0	.0	22747.5	26451.2	29747.5	112.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэлт	7457.3	8237.7	6258.9	2530.1	4075.0	161.1
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа	438.5	510.1	480.1	250.6	315.6	125.9
Шахмал түлш үйлдвэрлэлт	.0	.0	11628.2	.0	.0	0.0
Барилгын материал үйлдвэрлэлт / блок /	.0	.0	5260.3	.0	.0	0.0
Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	85086.9	194723.8	139895.2	82136.6	168241.8	204.8
Дулаан, уур үйлдвэрлэлт	73526.7	173207.4	109013.2	59628.6	131724.0	220.9
Ус ариутгал, усан хангамж	11560.2	21516.4	30882.0	22508.0	36517.8	162.2

2.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ, салбараар, жил бүрийн 2

Аж үйлдвэрийн салбар	2009 XI	2010 II	2011 II	2012 II	2013 II	2013.II% 2012.II
Аж үйлдвэр-Бүгд	326901.4	253003.1	537900.8	567943.9	1051461.0	185.1
Уул уурхайн олборлох салбар	158340.7	.0	49891.0	195084.8	167688.2	86.0
Нүүрс олборлолт	158340.7	.0	49891.0	195084.8	167688.2	86.0
Боловсруулах аж үйлдвэр	83473.8	58279.3	230999.4	152489.6	441773.8	289.7
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	30770.5	.0	123185.4	86256.3	298063.4	345.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	29352.4	40811.7	65805.6	33654.2	69745.8	207.2
Согтууруулах ундаа үйлдвэрлэл	2786.0	.0	.0	.0	.0	0.0
Оёдол, нэхмэлийн үйлдвэрлэл	7457.3	8237.7	27046.8	28974.3	67523.1	233.0
Мод модон эдлэл үйлдвэрлэл	12669.1	8719.8	7441.8	3238.1	6021.5	186.0
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа	438.5	510.1	627.4	366.7	420.0	114.5
Шахмал түлш үйлдвэрлэлт	.0	.0	.0	.0	.0	0.0
Барилгын материал үйлдвэрлэл /блок/	.0	.0	6892.4	.0	.0	0.0
Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	85086.9	194723.8	257010.4	220369.5	441999.0	200.6
Дулаан, уур үйлдвэрлэл, усан хангамж	85086.9	194723.8	257010.4	220369.5	441999.0	200.6

3. ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, жил бүрийн 02-р сарын байдлаар

Сумын нэр	Нийт орлого, оны үнээр, сая.төг		Хүн амаас	
	2012 II	2013 II	2012 II	2013 II
Бүгд дүн	46.435	44.063	21.335	21.574
Баян-агт	2.763	3.028	1.898	2.728
Баяннуур	0.621	0.574	0.156	0.268
Бугат	0.178	0.076	0.28	0.176
Бүрэгхангай	0.0	0.0	0.00	0.0
Гурванбулаг	1.276	1.466	0.014	0.396
Дашинчилэн	1.848	1.095	0.137	0.683
Могод	0.283	1.037	0.928	0.281
Орхон	0.034	1.556	0.178	0.037
Рашаант	1.248	0.525	0.046	0.689
Сайхан	1.806	3.725	0.989	0.511
Сэлэнгэ	0.0	0.0	0.029	0.0
Тэшиг	0.644	0.155	0.594	0.431
Хангал	0.0	0.0	0.00	0.0
Хишиг-Өндөр	0.679	1.007	0.725	0.338
Хутаг-Өндөр	0.384	2.206	0.399	0.233
Уурхай	0.957	2.150	2.489	0.956
Булган	33.740	25.463	12.4725	12.847

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

	2010-II	2011-II	2012-II	2013-II
Нийт нас баралт	60	61	54	39
эмнэлэгт нас баралт	17	9	9	7
хоног болоогүй нас баралт	2	4	0	0
0-5 насны нас баралт	4	2	2	1
0-1 насны нас баралт	3	2	2	1
нас барсан эх	0	0	0	0
Урьдчилан сэргийлэх тарилгын хувь	99.6	98.2	100.0	99.7
Ор хоног	19612	16306	19645	18114
Амбулаторын үзлэг	33669	32100.0	30656	35103
Диспансерийн хяналтын хувь	6.7	6.0	6.3	6.8
Гэрийн дуудлагын хувь	4.7	3.8	4.6	4.4
Сумын их эмчийн үзлэгийн хувь	54	34.2	47.6	45.7

4.1 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

Үзүүлэлт	2010-II	2011-II	2012-II	2013-II
Нийт халдварт өвчин	129	161	215	160
Гэдэсний халдварт өвчин	22	64	104	13
вируст гепатит	21	64	104	13
цусан суулга	0	0	0	0
сальмонеллэз	0	0	0	0
халдварын гаралтай суулгалт	1	0	0	0
Амьсгалын замын халдварт өвчин	18	22	23	95
гар хөл амны өвчин	0	0	0	0
энтервирусын халдвар	0	0	0	0
улаанууд	0	0	0	0
салхин цэцэг	6	21	12	25
улаан эсэргэнэ	0	0	0	0
гахайн хавдар	0	0	0	63
сүрьеэ	12	1	11	7
Байгалийн голомтод халдварт өвчин	0	0	2	0
хачигт энцефалит	0	0	0	0
хачигт рикеттиоз	0	0	0	0
бруцеллэз	0	0	2	0
боом	0	0	0	0
Бэлэгсийн замаар дамжих халдвар	80	72	82	40
тэмбүү	4	6	12	14
трихомониаз	58	48	53	14
заг хүйтэн	18	18	17	12
Арьсны халдварт өвчин	31	7	10	14
мөөгөнцөр	9	3	4	12
хамуу	22	4	6	2
ёлом	0	0	0	0

* хамуу өвчин нь нийт халдварт өвчний нийлбэрт ордоггүй болно.

5.

ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙН САНГААС ОЛГОСОН ХУВЬ ХИШИГ												
мян.төг (өссөнөөр)												
Сумын нэр	Олгосон тэтгэвэр		Бүгд тэтгэмж, тусламж		Үүнээс:							
					Ахмад НМТ		ХБИ/ НМТ		ХБ /хүү /НМТ		БӨХАӨ	
	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг
Баян-Агт	102	19,088.9	45	3,116.8	24	1,467.2	10	864.0	11	785.6	0	-
Баяннуур	27	5,245.6	6	448.0	1	48.0	1	96.0	3	208.0	1	96.0
Бугат	32	6,481.9	15	1,406.4	6	648.0	5	480.0	4	278.4	0	-
Булган	351	60,887.6	224	20,161.8	75	6,539.3	102	9,942.5	42	3,296.0	5	384.0
Бүрэгхангай	37	7,562.8	18	1,584.0	7	624.0	6	528.0	5	432.0	0	-
Гурванбулаг	34	6,941.2	21	1,873.6	10	945.6	4	336.0	6	496.0	1	96.0
Дашинчилэн	59	10,991.9	27	2,839.5	19	1,893.8	2	166.4	5	731.2	1	48.0
Могод	40	8,517.4	18	1,499.2	7	572.8	6	579.2	4	299.2	1	48.0
Орхон	60	13,005.6	38	3,945.7	17	1,977.7	7	624.0	11	1,056.0	3	288.0
Рашаант	60	11,573.6	61	4,462.4	26	2,016.0	24	1,344.0	9	910.4	2	192.0
Сайхан	88	17,308.1	31	2,942.4	18	1,940.8	10	713.6	2	192.0	1	96.0
Сэлэнгэ	56	10,929.8	48	4,444.8	25	2,243.2	16	1,460.8	7	740.8	0	-
Тэшиг	103	19,362.7	48	5,262.4	30	3,120.0	9	865.6	9	1,276.8	0	-
Хангал	33	6,022.6	23	1,951.8	12	1,081.6	6	534.2	3	144.0	2	192.0
Хишиг-Өндөр	64	11,305.4	45	3,872.0	24	2,176.0	9	672.0	8	640.0	4	384.0
Хутаг-Өндөр	119	21,351.5	75	6,544.4	41	3,668.4	20	1,855.6	12	828.4	1	96.0
Хялганат	73	14,583.5	32	3,120.0	11	1,056.0	12	1,200.0	9	864.0	0	-
Дүн	1338	251,160.1	775	69,475.2	353	32,018.4	249	22,261.9	150	13,178.8	22	1,920.0

Хүснэгт-1-н үргэлжлэл

Сумын нэр	Жирэмсэн хөхүүл эхийн		Алдарт эхийн одон			
			I		II	
	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг	хүн/т	мян.төг
Баян-Агт	82	5,760.2	65	13,000.0	151	15,100.0
Баяннуур	42	3,685.0	49	9,800.0	71	7,100.0
Бугат	40	3,874.7	58	11,600.0	89	8,900.0
Булган	634	23,880.8	346	69,200.0	541	54,100.0
Бүрэгхангай	43	3,480.0	66	13,200.0	120	12,000.0
Гурванбулаг	62	6,240.0	115	23,000.0	162	16,200.0
Дашинчилэн	60	4,143.0	82	17,400.0	126	12,600.0
Могод	38	4,494.7	80	16,000.0	137	13,700.0
Орхон	50	4,831.4	106	21,200.0	148	14,800.0
Рашаант	61	6,774.7	88	17,600.0	150	15,000.0
Сайхан	91	7,379.9	111	22,200.0	188	18,900.0
Сэлэнгэ	61	5,550.7	101	20,200.0	167	16,700.0
Тэшиг	72	5,152.7	114	22,800.0	149	14,900.0
Хангал	37	1,721.8	48	9,600.0	74	7,400.0
Хишиг-Өндөр	112	5,070.3	100	20,000.0	142	14,300.0
Хутаг-Өндөр	112	7,843.9	136	27,200.0	222	22,400.0
Хялганат	65	4,650.3	76	15,000.0	143	14,300.0
Дүн	1662	104,534.1	1741	349,000.0	2780	278,400.0

6. НИЙГМИЙН ДААТГАЛ, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, даатгуулагчдын тоо, олгосон тэтгэвэр

Үзүүлэлт	сая.төг	
	2013-II	
	хүн.тоо	зарцуулсан хөрөнгө
Тэтгэврийн даатгалын сан	6960	2774.1
<i>Өндөр настны</i>	5338	2174.2
<i>Тахир дутуугийн</i>	976	331.9
<i>Тэжээгчээ алдсаны</i>	488	160.8
<i>Цэргийн</i>	158	106.6
<i>Бусад</i>	0	0.6
Тэтгэмжийн даатгалын сан	200	75.8
ХЧТА тэтгэмж	61	3.7
ЖА тэтгэмж	96	59.2
Оршуулгын тэтгэмж	43	12.9
ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон	62	35.002
ТД	50	30.7
ТА	7	3.3
Тэтгэмж	1	0.3
Сувилал	4	0.7
Бусад	0	0.002
Ажилгүйдлийн даатгалын сан	112	34.1
Тэтгэмж	112	34.1
Сургалт	0	0
Эрүүл мэндийн даатгалдын сан	5068	175.8
Тусламж үйдчилгээ	5068	175.8
Эмийн үнийн хөнгөлөлт	0	0

7. ХААҮЙН ДЭЭЛТ ЦАО ҮҮҮЭЭЛТ ИҮҮҮ

Үзүүлэлт	Нийт	эмэгтэй
Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд	225	128
Тайлант сард нэмэгдсэн ажилгүйчүүд	21	17
бусад	21	17
Тайлант сард ажилд орсон	11	9
төрийн байгууллагад	11	9
бусад	0	0
Тайлант хугацаанд хасагдсан идэвхигүйн улмаас	76	32
Сарын эцэст байгаа ажилгүйчүүд	159	104
Урьд ажил хийж байсан	0	0
Анх удаа ажил эрж байгаа	159	104
Насны бүлгээр: 16-24	11	6
25-34	61	50
35-44	49	17
45-60	38	31

8. ӨИЙ АЭҮЙ ЦЭ АОНҮЙ ӨИВИААЙЕ

Өзөгнөлд -8-1

Хорогдсон бүгд									
	2012 II	2013 II	Оны эхний малд эзлэх хувь	үүнээс					2013 2012 зөрүү
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
Баян-агт	197	432	0.2	0	65	83	143	141	235
Баяннуур	181	1026	1.0	0	0	47	353	626	845
Бугат	29	59	0.1	0	19	9	20	11	30
Булган	0	56	0.1	0	8	3	26	19	56
Бүрэгхангай	0	166	0.1	0	20	15	58	73	166
Гурванбулаг	0	305	0.1	0	0	0	180	125	305
Дашинчилэн	102	262	0.1	0	16	8	101	137	160
Могод	446	305	0.1	0	45	11	144	105	-141
Орхон	205	302	0.1	0	17	47	93	145	97
Сайхан	505	169	0.1	0	33	17	64	55	-336
Сэлэнгэ	0	462	0.6	4	16	74	202	166	462
Тэшиг	182	904	1.3	0	49	93	460	302	722
Хангал	0	168	0.2	0	6	21	139	2	168
Хишиг-Өндөр	459	434	0.3	0	14	17	164	239	-25
Хутаг-Өндөр	229	869	0.5	0	10	123	314	422	640
Рашаант	0	664	0.4	0	0	0	222	442	664
Дүн	2535	6583	5.3	4	318	568	2683	3010	4048

Өзөгнөлд -8-1 2 даууаеуе

Өвчнөөр									
	2012 II	2013 II	Оны эхний малд эзлэх хувь	үүнээс					2013 2012 зөрүү
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
Баян-агт	0	160	0.079	0	15	25	59	61	160
Баяннуур	0	0	0.000	0	0	0	0	0	0
Бугат	0	40	0.057	0	0	9	20	11	40
Булган	0	5	0.009	0	0	0	3	2	5
Бүрэгхангай	0	0	0.000	0	0	0	0	0	0
Гурванбулаг	0	0	0.000	0	0	0	0	0	0
Дашинчилэн	0	0	0.000	0	0	0	0	0	0
Могод	0	18	0.008	0	2	1	9	6	18
Орхон	0	0	0.000	0	0	0	0	0	0
Сайхан	0	7	0.003	0	0	0	0	7	7
Сэлэнгэ	0	15	0.019	0	0	3	8	4	15
Тэшиг	80	104	0.149	0	5	17	34	48	24
Хангал	0	11	0.014	0	0	8	1	2	11
Хишиг-Өндөр	0	0	0.000	0	0	0	0	0	0
Хутаг-Өндөр	0	0	0.000	0	0	0	0	0	0
Рашаант	0	0	0.000	0	0	0	0	0	0
Дүн	80	360	0.014	0	22	63	134	141	280

Хээлтэгч									
	2012 II	2013 II	Оны эхний малд ээлэх хувь	үүнээс					2013 2012 зөрүү
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
Баян-агт	0	29	0.030	0	0	3	11	15	29
Баяннуур	0	0	0.000	0	0	0	0	0	0
Бугат	0	0	0.000	0	0	0	0	0	0
Булган	0	11	0.039	0	1	1	5	4	11
Бүрэгхангай	0	99	0.092	0	10	11	38	40	99
Гурванбулаг	0	0	0.000	0	0	0	0	0	0
Дашинчилэн	0	35	0.039	0	0	1	16	18	35
Могод	20	44	0.041	0	6	3	17	18	24
Орхон	23	72	0.075	0	2	7	25	38	49
Сайхан	64	73	0.070	0	16	7	30	20	9
Сэлэнгэ	0	0	0.000	0	0	0	0	0	0
Тэшиг	34	95	0.305	0	11	13	38	33	61
Хангал	0	1	0.003	0	0	1	0	0	1
Хишиг-Өндөр	184	88	0.110	0	0	0	50	38	-96
Хутаг-Өндөр	59	144	0.165	0	0	16	51	77	85
Рашаант	0	0	0.000	0	0	0	0	0	0
Дүн	384	691	0.968	0	46	63	281	301	307

9. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Хэргийн төрөл	2012 II	2013 II	$\frac{2013 \text{ II}}{2012 \text{ II}} \%$
Бүртгэгдсэн хэрэг - бүгд	46	70	152.2
Бусдыг санаатай алсан	0	0	-
Бусдыг болгоомжгүйгээр алсан	0	0	-
Хүчингийн хэрэг	0	0	-
Танхайн хэрэг	1	3	300.0
Малын хулгай	15	18	120.0
Иргэдийн өмчийн хулгай	12	24	200.0
Дээрэм, булаалт	1	1	100.0
Ашиглалт	0	0	-
ХАБЭГэмт хэрэг	6	4	66.7
Гал түймрийн хэрэг	0	0	0.0
ИЭЧЭМ-ийн эсрэг гэмт хэрэг	8	15	187.5
Албан тушаалын хэрэг	0	0	-
Бусад	3	5	166.7

9.1. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ,сумаар

Сумын нэр	2012 II	2013 II	$\frac{2013 \text{ II \%}}{2012 \text{ II}}$
Бүгд дүн	47	70	148.9
Баян-Агт	3	2	66.7
Хутаг-Өндөр	2	5	250.0
Гурванбулаг	1	0	0.0
Сайхан	1	1	100.0
Тэшиг	1	2	200.0
Сэлэнгэ	7	2	28.6
Хялганат	1	2	200.0
Бүрэгхангай	3	4	133.3
Баяннуур	0	0	
Хангал	3	1	33.3
Бугат	2	3	150.0
Орхон	2	7	350.0
Дашинчилэн	0	3	
Хишиг-Өндөр	2	8	400.0
Булган	16	21	131.3
Могод	1	6	600.0
Рашаант	2	3	150.0

